

## МОНГОЛ - АНУ-ЫН ХАРИЛЦАА, МОНГОЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

МУИС, ОУХС-ийн багш,  
Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин  
**Х.Олзвой**

АНУ бол далайн хүчний их гүрэн бөгөөд нөлөө, нөөлгөө дэлхийн аль ч өнцөгт хүргэхийг хэзээнээсээ эрмэлзэж ирсэн орон. Хятад, Оросын дунд оршдог Монгол улсыг стратегийн хувьд хэдийнээс сонирхож байснаас гадна Монголын талаас ч харилцаа тогтоох олон оролдлого хийж байсан билээ. Академич Б.Лхамсүрэн гуай "Монголын тусгаар тогтнолыг хязгаарлан цуцлах үед Хүрээний эрх баригчид Америкийн Нэгдсэн улсаас дэмжлэг олохыг идэвхтэй оролдож байв"<sup>1</sup> гэдгийг тэмдэглээд Хүрээнд АНУ-ын консулын газар нээх, ер нь АНУ Монголыг шууд хамгаалалтандаа авах талаар удаа дараа хүсэн ярилцаж байсан баримтыг бичсэн байдаг. Гол нь Монголын тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэхэд эдгээр оролдлого чиглэсэн байдаг.

Да лам Пунцагдорж АНУ-ын Хятад дахь ерөнхий консул Чарльс Эберхардтай 1920 оны 4-р сард уулзахдаа Монголын асуудлыг зориуд сонирхон тэсвэрлэшгүй хүнд байдлаас ангижруулахыг хүсч байсныг Б.Лхамсүрэн гуай бас дурдсан нь буй. АНУ-ын судлаач А.Кемпи ч 1988 онд хамгаалсан диссертацийн ажилдаа ерөнхий сайд Бодоо, Богд гэгээн нараас АНУ-д хандан бичиж байсан тусгаар улс болгохыг дэмжих өгөхийг хүссэн захидал бичгийн хуулбарыг хавсаргаж Хаалган дахь АНУ-ын консул нартай харилцаж байсныг баримттай бичсэн байдаг. 1920-иод оны үед Хятад улс Монголыг өөрийн хэсэг хэмээн үзэж бусдад алдахгүй байхыг хичээж байсан баримтууд, мөн АНУ Монголыг Хятадын хэсэг гэж үзэж байсан тухай А.Кемпийн диссертацид тодорхой өгүүлсэн байдаг.<sup>2</sup> Энэ бүхэн бол Монголчууд тусгаар тогтнол, аюулгүй байдлын асуудлаа гурав дахь түнш, юуны өмнө АНУ-ын дэмжлэгтэй шийдвэрлэхийг зорьж байсныг батлах байх гэж үзэж болох юм.

Монгол, Америкийн харилцаа олон жилийн турш "Хүйтэн дайн"-ы уур амьсгал, ЗХУ-ын нөлөөний дунд явсан боловч ойртох, дипломат харилцаа тогтоохыг хоёр талаасаа сонирхож байсан билээ. 1910-1920-иод онд АНУ-ын консулууд Монголыг тандан судлаж, холбогдох эрх мэдэлтнүүдтэй уулзаж, 1944 онд АНУ-ын дэд ерөнхийлөгч Монголд заларч, АНУ-ын их эрдэмтэн О.Латтимор "... Монголыг гуравдахь орны статустай болгох нь Америкийн ашиг сонирхол болохсон билээ. Гэтэл бид энэ улс тусгаар тогтносон уу гэсэн эргэлзээ гарган Монголыг НҮБ-ийн гишүүн болохын эсрэг санал өгч алдаа хийж байна. ... Одоо Монгол коммунистуудын захиргаатай Орос, коммунистуудын хяналттай Хятадын

<sup>1</sup> Б.Лхамсүрэн. Монголын гадаад орчин төрийн тусгаар тогтнол, УБ, 1995, х.26

<sup>2</sup> Campi, A. The Political Relationship between The United States and outer Mongolia, 1915-1927: the Kalkan Conculer Records. 1988

дунд ор  
хүн ам  
нь Ам  
бичиж  
"голлох  
Ф.Рузве  
үүнийхэ  
1970-аад  
тогтоох  
бол Ор  
байж ма  
тодорхо  
ёсоор то  
Хуу

тэргүүтэ  
сэтгэлгэ  
бодлогы  
эхэлсний  
олон арв  
ЗХУ-ын  
д /хуучи  
бөгөөд  
харилцаа

Энэ  
өөрчлөлт  
дагаварт  
Х.Макин  
дундах "с  
Евразид  
алхам хи  
социалис  
бэхжих (с  
асуудлыг  
байсан ю  
АНУ-ын  
зайлхийг  
тод" байд  
билээ.

"Мон  
Москва х  
харилцаа  
тэмдэг бо  
талаар ч а

<sup>3</sup> Owen Littim  
<sup>4</sup> Asian Survey  
<sup>5</sup> Мөн тэнд



дунд оршиж байна. Ийм нөхцөлд Хятад, Оросын хилийн бүсэд 600 000 хүн ам газар нутагт нь оршиж буй энэ орны хувьд ач холбогдол өгөх нь Америкийн бодлогын хувьд давуу тал болохсон ...<sup>3</sup> гэж тодорхой бичиж байлаа. Мөн тэрээр Монголыг Орос, Хятадын дунд байрладаг "голлох орон" гэж үзэж байв. Ялтын хурал дээр АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт Монголын статус – квог бусдын хамт хүлээн зөвшөөрч үүнийхээ төлөө Хятадтай ажиллаж байсныг түүхэн баримт гэрчилдэг. 1970-аад онд Р.Никсоны засгийн газар Монголтой дипломат харилцаа тогтоохыг эрмэлзэж алхам хийж байсныг ч дурдах хэрэгтэй. Тэд Монгол бол Орос, Хятадын дундах "сонсох чих, харах нүд" гэж үзэж байсан ч байж магад. Тэгэхээр манай орон стратегийн чухал цэг, геополитикийн тодорхой бүс гэдэг нь тодорхой. Монгол улс, АНУ-ын харилцаа албан ёсоор тогтоосон нөхцөл байдлыг харахад их өөр мэт бодогдох юм.

Хуучин ЗХУ-ын нам, төр засгийн удирдлагад М.С. Горбачев тэргүүтэй шинэчлэл, өөрчлөлтийнхөн гарч, олон улсын харилцаанд "шинэ сэтгэлгээ"-ний бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн үеэс манай улсын гадаад бодлогын алхам бүрийг урьдчилан зааж байсан систем аажмаар нурж эхэлсний нэг илрэл нь АНУ-тай дипломат харилцаа тогтоох асуудлаар олон арван жил тавьж байсан "вето" хоригоосоо татгалзсан явдал юм. ЗХУ-ын Гадаад явдлын яамны сайд Э.А. Шевардназе 1986 онд БНМАУ-д /хуучин нэрээр/ айлчлах үедээ дээрх асуудлаар "ногоон гэрэл" асаасан бөгөөд 1987 оны нэгдүгээр сард Монгол, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон билээ.

Энэ нь Монгол улсын геополитикийн орчинд гарсан нэн чухал өөрчлөлтийн нэг төдийгүй Евразид гарсан цоо шинэ, холын үр дагавартай том үзэгдэл байсан юм. Чухамдаа АНУ Еврази буюу Х.Макиндерийн онолоор "Хаартлэнд"-ын төв хэсэгт, ЗХУ, БНМАУ-ын дундах "бамбай" оронд хөл тавьж, олон арван жил мөрөөдсөн хүсэл – Евразид гүнзгий нэвтрэх геополитикийн зорилгоо хэрэгжүүлэхэд чухал алхам хийсэн хэрэг байлаа. АНУ хэзээнээсээ Монголыг хүрээлэн буй социалист хоёр их гүрнийг /ЗХУ, БНХАУ/ ойроос сонсох, мэдрэх, Евразид бэхжих бодлого барьж байв. Иймээс ч Монгол – АНУ-ын харилцааны асуудлыг ЗХУ үргэлж хойш тавих, саатуулах байр сууринаас хандаж байсан юм. Яагаад гэвэл энэхүү газарзүй, улс төрийн хувьд эмзэг газарт АНУ-ын өчүүхэн ч гэсэн дипломат оролцоо байхаас Зөвлөлтийнхөн зайлсхийхийг хүсч байв".<sup>4</sup> Харин М. Горбачевын "шинэ сэтгэлгээ", "ил тод" байдлын үзэл санаа дээрх хатуу байр суурьт өөрчлөлт гаргасан билээ.

"Монголын хувьд гэвэл, Хятадуудад буулт хийн аргадах талаар Москва хир хол явах гэж буй нь ихээхэн бүрхэг байгаа энэ үед АНУ-тай харилцаагаа хэвийн болгох нь түүний тусгаар тогтнолын чухал бэлэг тэмдэг болох байв".<sup>5</sup> Мөн АНУ-тай ойртох нь худалдаа, эдийн засгийн талаар ч ашигтай гэж Монголд үзэж байжээ.

<sup>3</sup> Owen Littimore. The Situation in Asia, Boston, 1949, p.226

<sup>4</sup> Asian Survey, Vol.XXVII, no.1, January 1987, p.77

<sup>5</sup> Мөн тэнд



Дүгнэхэд 1987 оны 1-р сарын 27-нд Монгол, Америкийн хооронд дипломат харилцаа тогтоосон нь улс төр, геополитикийн хувьд нэн ач холбогдолтой болсон юм. Тухайлбал, манай улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал улам бэхжиж, ЗХУ-д өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийн бодлогыг цаашид ч үндэснийхээ язгуур эрх ашигт нийцүүлэн ашиглах шинэ боломжийг нээсэн юм. Монгол нутагт АНУ-ын бодит оролцоо бий болсон явдал манай улсаас гадаад руу чиглэсэн үйл ажиллагааг үзэл суртлын хүлээсээс аажмаар гаргахад эрч, итгэл нэмж, сэтгэл зүйн хувьд эерэг нөлөө үзүүлсэн гэж дүгнэж болно. Манайтай шууд хиллэж буй хоёр их гүрэн ч геостратегийн бодлогодоо энэ бүхнийг эрхбиш харгалзан үзэж байх шаардлагатай болсныг мөн харуулав.

1987 оноос өмнө хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох талаар хэд хэдэн оролдлого хийгдсэн билээ. Анхны хэлэлцээг АНУ-ын санаачилгаар 1961 онд хийж байсан бөгөөд "... энэ асуудалд өөрийн нааштай хандлагыг бид тэгэхэд хэлсэн билээ. Гэтэл АНУ, тэр цагийн олон улсын байдлын зарим тодорхой зүйлээр шалтаг болгож нэгэнт эхэлсэн хэлэлцээг зогсоосон юм. БНХАУ-ын засгийн газар, нийгэм - улс төрийн янз бүрийн байгуулалтай улсуудын хооронд хэвийн харилцааг энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр хөгжүүлэх бодлогоо урьдын адил баримталсаар байна" гэж Ю.Цэдэнбал "Нью-Йорк Таймс" сонины орлогч эрхлэгч ноён Т.Солсберийн асуултад өгсөн хариултдаа дурдсан байдаг.<sup>6</sup>

Дипломат харилцаа тогтоох асуудлаар уулзалт - хэлэлцээ 1973 онд ч болж байлаа. Гэвч 1960-аад оны оролдлого бүтэлгүй болсны шалтгааныг АНУ-ын төрийн департаментын ажилтан Кеннет Жэрретт "АНУ-ын хувьд харилцааг хэвийн болгоход хоёр гол саад байсан юм. Үүнд: Монголын талаархи үндсэрхэг хятадуудын нутаг дэвсгэрийн санаархал, Монгол бол ЗХУ-ын өөр нэгэн БНУ-аас хэтрэхгүй, бүрэн эрх багатай улс гэсэн үзэл бодол..."<sup>7</sup> гэж тайлбарлажээ.

Харин 1970-аад оны хувьд ЗХУ-ын "хориг" гол саад болсон байх. Яагаад вэ гэвэл 1972 онд АНУ-ын ерөнхийлөгч Р.Никсон БНХАУ-д айлчилж харилцаа нь хэвийн болсны дараа үндсэрхэг Хятадуудын татгалзал онцгой ач холбогдолгүй болсон бөгөөд Ж.Картерийн засгийн газрын үед тухайн орны бодлогыг үл харгалзан тогтоох чиг шугам давамгайлсан нь "Монголын бие даасан байдлын жинхэнэ эсэхэд эргэлзэх явдал ач холбогдлоо алдахад" хүргэжээ. Зөвлөлт, Хятадын хилийн мөргөлдөөн, энэ хоёр гүрний зөрчил тэмцэл дээд цэгтээ тулаад байсан үед АНУ-ын хувьд "сонсох чих, ажиглах нүд" хэрэгтэй байсан нь мэдээж бөгөөд иймээс ЗХУ, БНХАУ-ын хоорондох геостратегийн байрлалтай Монголын ач холбогдол тэр үед нэмэгдсэн гэж болно.

1986 онд М.Горбачев Азийн бодлогоороо Владивостокт өргөн хөтөлбөр дэвшүүлж Азийн орнуудтай харилцаагаа сайжруулах, хориг

<sup>6</sup> Ю.Цэдэнбал. МАХН, Ардын төрийн гадаад бодлогын тухай. УБ, 1981. х.372

<sup>7</sup> Kenneth Jarrett. Mongolia in 1987: Out from the Gold? in "Asia Survey". vol, XXVIII. no.1, January 1988, p.78



саадаа арилгах замд орсон нөхцөл байдлыг Монгол улс түргэн ашиглаж АНУ-тай ийнхүү хэвийн дипломат харилцаа тогтоож түүнээ бэхжүүлэх чиглэлээр шийдвэртэй алхмууд хийж эхэлсэн бөгөөд БНХАУ-тай ч улс төр, эдийн засгийн харилцаагаа сэргээн хөгжүүлэх чиглэлээр ажилласан юм. Энэ бүхэн эцсийн эцэст Монголын геополитикийн орчинд мэдэгдэхүйц өөрчлөлт оруулсан билээ.

Монголын гадаад харилцааг АНУ-ын хэвлэлд он оноор дүгнэн бичсэнээс үзвэл:

- "1987 онд Монгол олон талтай болж байна. АНУ-тай харилцаж, Хятадтай өөрийн холбоо хэлхээг цаашид сайжруулж буй нь Монголд өөрийн байр суурин дээр зогсох шинэ сонголт, их боломж өгөв". /дээр дурдсан Кеннет Жеррет/

- 1988 онд "Москвацийн шууд бус зөвшөөрөлтэйгөөр Монгол социалист биш ертөнцтэй ... хэлхээ холбоогоо өргөтгөсөөр байв". Монгол гадаад бодлогод өнөө үе хүртэлхээсээ илүү боловсорсон, урагшилсан хандлагаа батлахын хамт Москвагаар тогтоосон цэрэг - улс төрийн холбоогоо хатуу хадгалж байна.<sup>8</sup>

Дээрхээс дүгнэвэл, дипломат харилцаа тогтоосны дараахи 2-3 жилд "Монгол - Америкийн харилцаанд геополитикийн ач холбогдолтой томоохон алхам төдийлөн хийгдээгүй өнгөрчээ. Энэ нь бас АНУ-ын элчин сайд асан Алфонсе Ф. Ла Порта нарын тэмлэглэсэнчлэн хоёр тал бие биеэ сайн мэдэхгүйгээс<sup>9</sup> гадна Монгол Москвагийн "зангаас" бүрэн чөлөөлөгдөх алхмыг удаашруулсантай холбоотой. Харин Улаанбаатарт, Монгол Вашингтонд элчин сайдын яамаа байгуулсан боловч АНУ-ын элчин сайд Улаанбаатарт суурин суухгүй, ирж очин байв. Хоёр тал "ил тод байдал", ЗХУ -ын задрал болон Монгол, Зүүн Европ зэргээс Зөвлөлтийн цэрэг гарах асуудлыг анхаарч зууралдаж байлаа. Харилцаа ойр дотны гэхээсээ зөв байсан гэвэл таарна. Зөвлөлтийн дараахи үеийн социалист системийн ирээдүйн талаар ихээхэн эргэлзээ байлаа" гэж Алфонсе Ф. Ла Порта дурдсан байдаг.

Монголд гарсан ардчилсан хөдөлгөөн манай улс, АНУ-ын харилцаанд "шинэ гэрэл" асаасан юм. Монголыг Төв Азийн Бүгд Найрамдах улсууд болон хуучин ЗХУ-ын бусад улсын адилаар шилжилтийн үед орсон ардчилсан улс гэж үзэж, улс төрийн либералчлалд нь "түргэн, эрт" дэмжлэг үзүүлсэн. Ингээд АНУ -ын элчин сайд байнга сууж эхэлжээ. Тэр үеийн Төрийн Нарийн бичгийн дарга Ж.Бейкерийн 1990, 1991 онд Монголд хийсэн айлчлал нь АНУ Монголын ардчиллыг нааштайгаар угтаж буйг харуулж, харилцааг өргөтгөх, ач холбогдолтой болгоход нөлөөлсөн. Ж.Бейкер 1990 онд айлчлах үедээ АНУ Монголын хувьд "гуравдахь түнш" байж болох үзэл

<sup>8</sup> А.Сандерс. Mongolia in 1988: Year of Renewal. Asian Survey.vol.XXIX.no.1 Jan.1989, p.53

<sup>9</sup> Элчин сайд Алфонсе Ф.Ла Порта, Дебра А.Гроссмен нарын бичсэн "The Future is now" өгүүлэл (The Mongolian Journal of International Affairs, no.5,1998,p.3)-д "АНУ-д Монголыг үл мэдэх явдал өнөө хэр нь хязгаарлах хүчин зүйл болж байна.Өнгөрсөн үед Монгол бол АНУ-ын хувьд албан ёсны *terra incognita* - үл мэдэх нутаг байсан бол олонхи монголчуудын хувьд АНУ үл мэдэх улс байсантай адил..." гэж бичжээ.



санааг дэмжихийн хамт харин Монгол улс хил залгаа хоёр хөрштэйгээ харилцаагаа муутгаж болохгүй гэдгийг анхааруулсан байдаг.

Төрийн нарийн бичгийн дарга М.Олбрайт 1998 онд Монголд айлчлах үед гаргасан “Монгол – Америкийн харилцааны тухай хамтарсан мэдэгдэлд” дурдахдаа “... Төрийн нарийн бичгийн дарга Олбрайт Монгол улс өөрийн хоёр хөрш ОХУ, БНХАУ- тай болон бүсийн бусад оронтой харилцаагаа сайжруулан өргөтгөхөө үргэлжлүүлж байгаад сэтгэл ханамжтай буйгаа илэрхийлэв”<sup>10</sup> гэжээ.

Монгол улс өөрийн нутаг дэвсгэрийг цөмийн зэвсгээс чөлөөтэй бүс гэж зарласантай холбогдуулан АНУ –ын тал 1993 оны 10-р сард мэдэгдэл гаргаж АНУ Монголын энэхүү статусыг дэмжиж буйгаа илэрхийлэхийн хамт Монголын тусгаар тогтнолд аюул учирваас АНУ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд нэн даруй хандах болно гэдгээ онцлон дурдсан нь манай улсын аюулгүй байдлын хувьд чухал ач холбогдолтой алхам болсон юм.

1996 онд Монгол улс, АНУ –ын засгийн газрууд цэргийн салбарт хамтран ажиллах хэлэлцээрт гарын үсэг зурсан бөгөөд түүнд цэргийн асуудлаар болох хуралдаанд монголчуудыг оролцуулах, цэргийн сургуульд сонсогч сургах, богино хугацааны цэрэг – стратегийн курс, семинарт Монголыг оролцуулах, цэргийн шугамаар хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, “баланс мэжик” нэрээр цэргийн хамтарсан сургууль хийх зэрэг арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. Мөн 1998 оны 10 дугаар сард АНУ–ын Батлан Хамгаалах Яамнаас гаргасан “Зүүн Ази, Номхон далайн бүсэд зориулсан АНУ-ын аюулгүй байдлын стратеги” гэсэн баримт бичигт Монголын тухай тусгайлсан зүйл тусгагдсан бөгөөд түүнд “...1987 онд дипломат харилцаа тогтоосноос хойш АНУ Монголтой нэн сайн харилцаатай байж ардчилал, чөлөөт зах зээлд зорьсон Монголын эрмэлзлэлийг, мөн Ази, Номхон далайн аюулгүй байдлын бүгцийн хэсэг болох түүний хүсэлт – тэр нь манай ашиг сонирхолд нийцэж байгааг АНУ дэмжиж ирэв.

Монгол улс АСЕАН–ний бүсийн чуулгын гишүүн болсонд АНУ баяр хүргэж буй бөгөөд ойрын жилүүдэд Монгол улс Ази, Номхон далайн цэргийн хүчинтэй холбоотой олон талт өргөн уулзалт, чуулгануудад оролцоход дэмжлэг үзүүлнэ. Үүнээс гадна олон улсын хөтөлбөрийн дагуу хийгдэх цэргийн төрөлжсөн сургалт, боловсрол, онцгой нөхцөл, энхийг сахиулах, хүмүүнлэгийн тусламж зэрэг салбарын сургалтыг АНУ дэмжих болно. АНУ олон улсын аюулгүй байдлын асуудлаар яриа хэлэлцээний тухай манай бодлогыг өргөтгөж дээд хэмжээнд улс төр, цэргийн солилцоог тогтмол явуулахыг дэмжинэ<sup>11</sup> гэж тэмлэглэсэн нь ач холбогдлоор гүнзгий санаа агуулсныг харуулж байна.

АНУ –ын эрдэмтдийн дотор ч Монголыг сонирхох, судлах явдал өргөсч байна. 1998 оны 6 дугаар сард Монгол, Америкийн хоёр талын

<sup>10</sup> The Mongolian Journal of International Affairs, no.5,1998,p.123

<sup>11</sup> US East Asia – Pacific Security Strategy (US Defence Department Bulletin, October 29,1998).

Г.Тумурчулуун “Процесс принятия внешнеполитических решений в малых государствах / на примере Монголии/, Москва, 1999,стр.38-39



бага хурал Улаанбаатарт болсон бөгөөд үүгээр хоёр орны эрдэмтэн, мэргэжилтнүүд Ази, Номхон далайн өнөө ба ирээдүйн асуудлыг хэлэлцсэн бөгөөд АНУ-ын төлөөлөгчдийг Калифорнийн их сургуулийн тэргүүлэх профессор Роберт Скалапино толгойлж ирсэн билээ. Тэр үед хуралд оролцогчид зарим асуудлаар санал зөрөөтэй байсан боловч проф. Р.Скалапиногийн тэмлэглэсэнчлэн "Америкчууд, монголчууд урт замын эхэн дээр байна. Бид зөвхөн бие биеэ танин мэдэхийг чармайж байна."<sup>12</sup> Үүнээс хойш 10 жилийн дараа Монголд ирсэн проф. Алвин Мажид, Ричард В.Мэнсбах нарын бичсэн "XXI зуун дахь Монголын аюулгүй байдал: холбоотон биш нөхөр ба түншийн эрэлд"<sup>13</sup> өгүүлэлд хэд хэдэн сонин санааг цохон тэмдэглэсэн байдаг юм. Тухайлбал:

- Орос, Хятадын аль нэг нь Монголд заналхийлвэл түүний эсрэг холбоотон болох улс Монголд байна уу гэвэл тийм холбоотон ерөөсөө олддохгүй. "Монголын газарзүйн түгжигдмэл байдал, АНУ мэтийн цэргийн ихээхэн хүч чадалтай бусад улсад Монгол харьцангуй ач холбогдолгүй улс, дайн байлдаанд олон хүний амь хохироохоос өрнөдөд нэмэгдсээр буй дургүйцэл нь Монголын хувьд цэргийн холбоотонг эрж хайхад тэр стратеги нь амжилтанд хүрэх заяагүй юм." Өнөөдөр Орос, Хятад хоёр Монголыг бие биенээсээ хамгаалах цэргийн чадавхи, сонирхолтой байх. Харин үр дүнд нь Монгол өмгөөлөгчөөсөө хамааралтай дагуул болох нь мэдээж.

- Монгол хоёр хөршийгөө бие биеийнх нь эсрэг чиглүүлсэн тэнцвэр барихыг оролдвол хоёул нутагт нь цөмрөн хүчээ үзүүлэх аюултай.

- Монгол өөрийн сул талыг ашиглан өөрийгөө хамгаалах талаар бодож үзэж болох юм. Энэ нь хоёр талынхаа анхаарлыг татаж болох үйл ажиллагаа явуулах, тийм бодлого хэрэгжүүлэхээс зайлсхийхэд оршино. Хамгийн аюултай нь Пан – Монголын үзлийг дэвэргэх явдал. Өвөр Монгол, Төвдийн байдал, Далай лам зэрэг "дотоод хэргийн" асуудлыг нь хөндвөл хүчирхэг БНХАУ зүгээр өнгөрөхгүй байх. Далай ламтай хэт нөхөрлөх нь "Америк найз нарын өнгөц дэмжлэг" авч болох авч "өс санагч, шунахай Хятад"-ын дургүйг хүргэнэ. / р. 18/

- Швейцарь шиг төвийг сахиж, хүйтэн дайны үеийн Финланд шиг ЗХУ-ын хувьд "амьдарна – тэд амьдраг" гэсэн бодлогыг баримталж байвал Хятад, Оросын зүгээс аюул багасах нь мэдээж.

- Монголын аюулгүй байдалд зөвхөн хоёр хөршийн зүгээс аюул учирна гэхээсээ монголчуудын олонхийн хувьд -ядуурал,-эрүүл мэнд, боловсролын байгууллагын доройтолт, хүрээлэн буй орчны бохирдолт илүү аюултай байж болох юм. "Угтаа ирэх жилүүдэд гадаадын албадлага, цэргийн түрэмгийллээс илүү том байж болох аюулыг дээрх байдал бий болгох магадлал байна." / р.19./

- Монголын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах нь Хятад, Оросын хувьд ч түүний тусгаар тогтнолын үнэ цэнийг ч өндөрсгөнө.

<sup>12</sup> Asian Survey, Vol. XXIX, no. 1. Jan. 1989, p. 50

<sup>13</sup> Alvin Majid and Richard W. Mansbuch. "Mongolian Security in the 21<sup>st</sup> Century: in Quest of Friends and Partners, not Allies" in The Mongolian Journal of International Affairs, no. 5, 1998, p. 10-26



Тэд бусад улсын адил Монголд хөрөнгө оруулах, хамтарсан үйлдвэр байгуулах нь ихсэнэ.

- АНУ, Өрнөд Европ, Япон, Хятад, Оростой Монгол улс найрамдал, түншлэл хөгжүүлэх талаар эхний шатандаа л байна. Ингэхийн тулд тэдгээр орны олон нийт, элит хэсгийн дотор өөрийн байр суурийг олох, нэр хүнд имижээ дээшлүүлэх хэрэгтэй. Энэхүү имижийн бүрэлдэхүүн хэсэгт Монгол бол социализмаас зах зээлийн эдийн засагт шилжих хүнд үеийнхээ дунд яваа, нээлттэй, ардчилсан нийгэм байгуулахыг эрмэлзэгч жижигхэн, аль ч улсад заналхийлэл учруулахгүй орон; Монгол өөрийнхөө адил шилжилтийн дунд үед орсон бусад бага буурай орон, түүний дотор ЗХУ задарсны дараа бий болсон Төв Азийн улсуудтай эвлэлдэх замаар имижээ дээшлүүлж чадах орон гэдгээ харуулах явдал хамаарагдана. Монголчуудын хувьд соёлын шинж төрхөөрөө америкчуудыг дагаж болох юм. Күнзийн уламжлалгүй, нүүдлийн соёл иргэншилтэй монголчууд бол тэгш эрхийн төлөө тэмцэгч/ухаалагч бодигальч үзэлтэн гэж өөрсдийгөө америкчуудад ойлгуулбал тэд ийм шинж төрхийг хүндэтгэгч учраас өөриймсөнө. Цаашилбал, "ардчилал", "чөлөөт зах зээл" -д монголчууд эргэлт буцалтгүй орсныг сурталчлах хэрэгтэй.

Эдгээр имижийг бусад бий болгохын тулд "найз, нөхөд", "түншүүд" -ийнхээ улс төрийн систем, нийгэм нь ямар янзтайг, хэрхэн "ажиллаж" буйг судалж мэдэх шаардлагатай. ЗХУ-тай нөхөрлөж байсан үед коммунист намууд, засгийн эрх баригч намуудын хооронд бат бэх хэлхээ холбоотой байвал л хэрэг бүтнэ гэж үздэг байсан монголчуудын хувьд АНУ-тай найзлан түншлэх нь АНУ-ын хувийн секторынхон, тэдний бүлэглэлүүд, хувь хүмүүстэй сайн харилцаа тогтоохыг шаардаж байгааг ойлгох ёстой. АНУ-ын конгресс, засаг захиргаанд Америкийн корпорациуд, шашны зүтгэлтнүүд, орон нутгийн албан хаагчид, тэр бүү хэл жуулчлалын байгууллагууд улс төрийн нөлөө үзүүлж чаддагийг ойлгох ёстой. Тэд бол "санал сэтгэгдэл бүрдүүлэгчийг манлайлагчид" бөгөөд асар олон цэргээс ч хүчтэйгээр Монголын хувьд явуулах бодлогод нөлөөлж чадна. / р.22-23/

Дээрх эрдэмтдийн санаа бодол нь "гуравдахь" түнштэй болохыг зорьж буй манай улсын хувьд чухал ач холбогдолтой бөгөөд бодлогод ч, арга барилд ч хэрэгтэй зүйл гэж үзэж байна. АНУ ардчилал, зах зээлд шилжиж буй улсын нь хувьд Монголд ач холбогдол өгч байгаа бөгөөд хоёр хөршөөс манай хувьд явуулах геостратегийн бодлогод нь нөлөө үзүүлэх чадвартай, түүнээ ч илэрхийлсэн их гүрэн юм.

#### Дүгнэхэд:

- Монгол бол Орос, Хятадын дунд, стратегийн чухал байршилтай учраас АНУ-ын хувьд геополитикийн тодорхой ач холбогдолтой улс

<sup>14</sup> Элчин хэлсэн үг  
<sup>15</sup> Мөн тэй



юм.<sup>14</sup> Монгол дахь АНУ-ын үндсэн ашиг сонирхол ардчилал, зах зээлд тулгуурласан эдийн засагт шилжих явдлыг дэмжихэд оршиж байна.<sup>15</sup>

- АНУ-ыг Монголын "гуравдахь түнш" болгохын тулд хоёр хөрш гүрэнтэйгээ хэвийн найрсаг, бүхэлдээ адил тэгш харилцаа барьж байх, АНУ-ын бодлого, нийгмийг судлан мэдэх, ойртох арга барилаа зөв тодорхойлох явдал туйлын чухал юм.

Эдгээрийн үндсэн дээр АНУ-тай харилцааг ойрын 10 жилд хөгжүүлэх үзэл баримтлал, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Орчин үеийн олон улсын харилцааны томоохон онцлог бол ертөнцчилөл, харилцан хамааралт байдал, интеграцчилал өргөжин тэлж, үндэс хальсан корпорациудын нөлөө, хүч ихэсч буй явдал билээ. Энэ нөхцөлд жижиг, буурай буюу хөгжиж буй орнууд их гүрнүүдтэй харилцаа барихдаа энэ бүхний үр ашиг, хор уршгийг сайтар дэнслэн бодсон геополитик явуулах ёстой гэж бодож байна.

Манай улсын Аюулгүй Байдал ялангуяа эдийн засгийн болон хүний аюулгүй байдлыг сайжруулах талаар АНУ-тай өргөн хамтран ажиллах шинэ, шинэ арга замыг сүвэгчилж байх нь өнөөгийн манай орны хөгжлийн түүхэн үед чухал бөгөөд хажуу талын санхүү, эдийн засгийн "мөлхөө нэвтрэлт" зэргийг ямар нэг хэмжээгээр хязгаартай байлгахад ач холбогдолтой гэж бодож байна.

Мөн АНУ-ыг системийн талаас нь судлах, ялангуяа геополитик, геостратегийн зорилт, чиглэлийг нь сайн мэдэх хэрэгтэй юм. Мөн хэт шүтэхгүй, хөгжлийн загварт нь хэт автагдахгүй байх нь манай үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэх буй заа.

Төгсгөлд нь хэлэхэд өнөөдөр нэг сонин үзэгдэл олон улсын харилцаанд харагдах шиг. Бид хоёр туйлт ертөнцөөс олон туйлт ертөнц рүү шилжсэн гэх. Гэтэл далайн хүчний геополитикийн ганц хүч ноёрхох болж байгаа юм биш биз! Үүнийг нь Европын орнууд дагаад ч байна уу! Тэгэхээр нэг туйлт хүч ноёрхох үе магад болоод байна уу гэмээр. АНУ (далайн хүч) хүйтэн дайнд ялаад геополитикийн орон зайгаа өргөсгөхөөр тэмүүлж эхлэх шиг боллоо. Иймд АНУ тэргүүтэй нэг туйлт ертөнц буй болбол орохгүй байх, хоёр хөршийн болон хөгжиж буй орнуудын байр суурийг ч харгалзан АНУ-тай аюулгүй байдлын асуудлаар түншлэх байр суурьтай байх нь зүйтэй болов уу.

<sup>14</sup> Элчин сайд Алфонсе Ф.Ла Порты Сенатын гадаад харилцааны хороонд томилогдохынхоо өмнө хэлсэн үгээс. The United States Information Service, Embassy of the USA Bulletin, September 25, 1997

<sup>15</sup> Мөн тэнд



---

Strategic location of Mongolia as a buffer state between Russia and China is much importance to US geopolitics as author explained in his article. It is also suggested that in order to make USA third partner of Mongolia, the country has to maintain normal, friendly and equal relations with its two partners and has to define right approach to keep close relations with USA through studying American policy and society as a whole. Based on it, he adds, a realistic program of action has to appear.

суу  
нө  
суу  
сог  
ан  
ну  
төл  
тул  
ун

ерт  
сар  
ши  
зам  
мэд  
нут  
суу  
Энэ  
ном

гүр  
зох  
айл  
үрг

1.1.

АН  
уулз  
айлч  
БНЭ